



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/485

Арвайхээр

г

Журам батлах тухай

т

Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.10, 16.16 дахь заалт, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1, 8.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/485 дугаар "Жагсаалт, журам батлах тухай" тушаал, Монгол Улсын "Төрөлжсөн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа"-ны MNS – 6330-2017 стандарт, Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260-2015-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эм зүйн тусламж үзүүлэх журмыг нэгдүгээр, хэрэглэх эмийн лавлахыг хоёрдугаар хавсралтаар баталсугай

2.Тушаалыг хэрэгжүүлэн зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эм зүйн албаны дарга (Ц.Мөнгөнтуяа), Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (Д.Болормаа) нарт даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга (Ц.Лувсандамдин)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Г.ДАШЖАНЦАН